

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын 1-р хавсралт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ СУРТАЛЧИЛГААНЫ
НЭГДСЭН ХӨТӨЛБӨР

2025-2028 он

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- 1.1. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах мэдээллийг сувгийн төрлүүд
 - 1.2. Нийгмийн даатгалын байгууллагын социал хаягаар олон нийтэд мэдээлэл хүргэж буй нөхцөл байдал
- ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

2.1. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.2. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой уламжлалт болон дижитал медиа салбарын судалгаа

ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ СУРТАЛЧИЛГААНЫ ТӨСӨВ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

3.1. Нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийтэд сурталчлах өнөөгийн төсөв

3.2. Цаашид Нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийтэд сурталчлах төсвийн төсөөлөл

3.3. Эрсдэлийн менежмент

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГАА БА СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө 2025-2028

4.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

НЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРТАЛЧИЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах мэдээллийг сувгийн төрлүүд

Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, үйлчилгээг олон нийтэд сурталчлахын тулд өмнө нь уламжлалт арга хэлбэр буюу Телевиз, сонин, радиогоор дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, үр өгөөжийн талаар ажил олгогч, даатгуулагч, иргэд, харилцагчдад хүргэж байсан. Харин мэдээллийн эрин үед уламжлалт аргаар нийгмийн даатгалын хууль тогтоомжийг олон нийтэд хүргэхээс гадна дижитал медиа буюу цахим платформ, цахим сувгуудаар дамжуулж байгууллагынхаа үйл ажиллагаа сурталчилгааг хийх боломж бүрдсэн. Өнөөдрийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд хүргэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд:

- Мөн www.ndaatgal.mn сайтаар дамжуулан мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж байна.
- Уламжлалт сурталчилгааны арга буюу хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд 1.7 сая хүн /16-аас дээш насныхан/ ашигладаг Фэйсбүүкээр дамжуулж, өөрсдийн байгууллагын хаягийг нээн (Нийгмийн даатгалын ерөнхий газар) мэдээллийг түгээж байна
- Залуучууд түлхүү ашигладаг /16-40 насныхан/ Инстаграммд мөн өөрийн байгууллагын хаягтай болж (Нийгмийн даатгалын ерөнхий газар) мэдээллийн түгээн ажиллаж байна.
- Зөвхөн видео бичлэг оруулах боломжтой “Youtube” сувагт /10-45 насныхан/ Нийгмийн даатгалын байгууллагын хаягийг нээн нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилсан Видео контент, рийл, шторкийг байршуулж түгээн ажиллаж байна.

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг, сурталчлах арга барил, сувгууд өөрчлөгдөж шинэчлэгдсээр байна. Энэхүү нөхцөл байдалтайгаа уялдуулан нийгмийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах арга барил, гарц шийдэл өөрчлөгдөж мэдээ, мэдээллийг түгээх суваг, хүртээмж нэмэгдэж нийгмийн даатгалын талаарх олон нийтийн дундах эерэг ойлголт нэмэгдэж байгаа ч сөрөг ойлголт ч байсаар байна. Гэхдээ сүүлийн гурван жилийн хугацаанд мэдээллийн хүртээмж нэмэгдсээр нийгмийн даатгалд даатгуулах даатгуулагчдын тоо 2022 онд 1.069.628, 2023 онд 1.105.843, 2024 онд 1.136.930 болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

1.2. Нийгмийн даатгалын байгууллагын социал хаягаар олон нийтэд мэдээлэл хүргэж буй нөхцөл байдал

Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг түгээх олон сувгууд нэмэгдэхийн хэрээр олон нийтийн дунд нийгмийн даатгалтай холбоотой илүү бодит мэдээллийг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлж байна. Жишээ нь 2024 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас болон @sigomongolia социал хуудсыг дагагчийн тоо **149638**, социал хаягаас **8.945.678** /давхардсан тоогоор/ хүн мэдээлэл авсан байна. Харин 2025 оны 6 дугаар сарын байдлаар нийт дагагчдын тоо **166.000** мянгад хүрч, **5.765.419** /давхардсан тоогоор/ хүн мэдээлэл авч байна. Дээрх тоон мэдээллээс харахад нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн хүртээмж ямар түвшинд байгааг тодорхойлж болно. Мөн байгууллагын цахим платформоор ямар ямар насны иргэд мэдээлэл авч байгааг зургаар харуулав. /Фэйсбүүк хуудасны тоон мэдээлэл/

Audience

Find out more about your followers

See all

149K Total followers
0.3% from previous 28 days

76.7% Women 23.3% Men

25-34

35-44

45-54

55-64

37.9%


37.2%

13.1%

4.9%


149,639 Total followers

+0% from previous 28 days



Нийгмийн даатгалын үр өгөөж, ач холбогдлын талаарх ойлголтыг зөв цэгцтэй өгөх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд өсвөр үе, залуучуудын түгээмэл ашигладаг платформоор дамжуулан “Нийгмийн даатгалын ерөнхий газар” нэртэйгээр инстаграмм хаягийг 2025 оны 03 дугаар

сарын 16-наас нээж хөгжүүлэн ашиглаж байна. Өнөөдөр буюу 2025 оны 06 дугаар сарын байдлаар буюу гурван сарын хугацаанд тус хаягийн дагагчдын тоо 411-г хүрч, нэг сарын дунджаар хандалтын тоо 6.900 /давхардсан тоогоор/ хүн тус хаягаас мэдээлэл авч байна. /Инстаграмм хаягийн тоон мэдээллийг зургаар хавсаргав /



Видео контент, рийл, шторкыг үзэж мэдээлэл авдаг хүмүүст зориулсан "Youtube" сувагт /10-45 насныхан/ Нийгмийн даатгалын байгууллагын хаяг нээж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилсан Видео контент, рийл, шторкийг байршуулж түгээн ажиллаж байна. Дагагчдын тоо бага хэдий ч сарын дундаж хандалт нь 102.0 мянга байгаа.

- Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх;
- Нийгмийн даатгалд итгэх итгэлийг төрүүлэх;
- Олон нийтэд Нийгмийн даатгалын талаарх зөв ойлголт өгөх, нийгэм дэхь ойлголтыг өөрчлөх;
- Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой сурталчилгааны ажлууд хийх;
- Олон нийтийг тогтмол мэдээллээр хангах;

2.2. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийтэд хүргэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд насны ангиллаар зорилтот бүлгийг тодорхойлж, нийгмийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах сурталчилгааны ажлыг хийхээр төлөвлөсөн.

- **18-35 насныхан:** Энэ насныхан нийгэмд үүссэн нийгмийн даатгалын талаарх сөрөг, буруу ойлголтоос болоод нийгмийн даатгалд хамрагдахыг хүсэхгүй байх тохиолдол их. Тиймээс нийгмийн даатгалд хамруулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Нийгмийн даатгалын үйлчилгээ, ач холбогдол, үр шимийн талаар тогтмол мэдээллээр хангах шаардлагатай. Мөн энэ насныхны сонирхол, анхаарлыг татах мэдээ, мэдээлэл, видео контент, рийлийг бэлтгэн нийлүүлж түгээн ажиллана.
- **35-45 насныхан:** Эд хөдөлмөр эрхэлж буй насныхан учир Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр нийгмийн даатгалын сангаас ямар ямар үйлчилгээг авах боломжтойг ойлгуулах, харин шимтгэл төлөхгүй байх, шимтгэл төлөлт тасарснаар цаашид гарах эрсдэл, сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлыг таниулах.
- **45-60 насныхан:** Тэтгэвэрт гарах нас дөхсөн, тэтгэвэрт гарсан насныхан учир тэдэнд тэтгэвэртэй холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх шаардлагатай, Жишээ нь эрэгтэй, эмэгтэй, малчин, туслах малчдын тэтгэвэрт гарах нас, тэтгэвэр гарахад шаардлагатай бүрдүүлэх материал, тэтгэвэр тогтоолгоход учирч болох эрсдэл, Нийгмийн даатгалын шимтгэл тэтгэвэр тогтоолгоход хэрхэн нөлөөлөх зэрэг мэдээллийг өгөх.
- **Бизнес эрхлэгч, ажил олгогчид:** Ажил олгогчид нийгмийн даатгалын тайлан гаргах, илгээхэд үүсдэг асуудлууд, нийгмийн даатгалын шимтгэлийг төлснөөр даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн авах

нөхцөлийг бүрдүүлж байдаг гэдэг ойлголтыг төрүүлэх, хугацаандаа даатгалын шимтгэлээ төлж байгаа Ажил олгогч, Бизнес эрхлэгчдийг урамшуулж, олон нийтэд танилцуулж, бусад ажил олгогчдыг нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх сэдлийг төрүүлэх ажлыг тогтмол хийж, хэрэгжүүлэх.

Зорилтот бүлгээ тодорхойлсон учир сурталчилгааны урт хугацааны нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах тухай

Нийгмийн даатгалын байгууллага 2025 онд Хэвлэл, мэдээллийн 15 байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хугацаанд рийл , постер, видео контент , стори рийл , онцлох мэдээ, шинэ мэдээ, нийтлэл, ярилцлага, тодруулга хийлгэж олон нийтэд түгээлгэхээр хамтран ажиллах бол, Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж, эерэг, сөрөг нөхцөл байдлын талаар тогтмол мониторингийн судалгаа хийлгэж, дүн шинжилгээ хийж байхаар мониторингийн 2 байгууллага, Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор мэргэжлийн пи ар сурталчилгааны 1 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. /Дээрх байгууллагуудын мэдээллийг хавсаргав./

2. Өөрсдийн нөөц бололцоог ашиглах тухай

НДЭГ-ын сошиал хаягууд болон хэрэглэгчийн лавлах утсанд ирж байгаа санал хүсэлт, олон нийтийн дунд өрнөж байгаа асуудлыг шүүн багцлан олон нийтэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. Байгууллагын веб хуудас, сошиал хаягуудаар олон нийтэд мэдээлэл хүргэх дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын **фэйсбүүк** хуудсаар дамжуулж:

- Сошиал хуудсаа ашиглан өөрийн бодит эх сурвалжаас мэдээлэл өгөх,
- Олон нийтэд хамгийн хүртээмжтэй хэлбэрээр контентоо бэлтгэж нийтлэх.
- Аль болох олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэл хүргэхийн тулд тодорхой кейс дээр мэдээллийг тайлбартайгаар хүргэх.
- Аймаг, дүүргийн НД-ын газрууд өөрсдийн боломж нөөцөд тулгуурлан иргэдээс ирж байгаа мэдээллийг тодорхой хугацаанд багцлан сошиал хуудсаараа олон нийтэд зориулж видео болон бусад хэлбэрээр контент болгон түгээх /Эргэх холбоо тогтоох нь хамгийн сайн сурталчилгаа болдог/
- Live-аар сэдвээ зарлаж мэдээлэл өгөх, оролцогчдын асуултад хариулах
- Цуврал постууд оруулах /Сайн дурын нийгмийн даатгал гэж юу вэ, Сайн дураар нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол гэх мэт/
- Зурган постер, инфографик

Нийгмийн даатгалын ерөнхий газрын **Инстаграмм** хуудас

- ✓ Рийл, Стори ашиглан зөвлөгөө өгөх, хуулиа тайлбарлах
- ✓ Залуусын анхаарал татах сонирхолтой ишлэл, зураг, НД-ын байцаагчийн нэг өдөр, өдөрт хэдэн асуултад хариулдаг вэ, хэдэн хүн хүлээн авдаг вэ гэх зэрэг мэдээллийг оруулах

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ СУРТАЛЧИЛГААНЫ
НЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа				Хүрэх үр дүн
	2025 он	2026 он	2027 он	2028 он	
Зорилт 1. Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Олон нийтэд мэдээлэх, сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг жил тутам шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажилласнаар нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.
Зорилт 2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан, хамтран ажиллах	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээ, мэдээллийг үйл ажиллагаа нь тогтворжсон нэр хүндтэй, хандалт ихтэй хэвлэл мэдээллийн байгууллагыг сонгон хамтран ажиллах гэрээ байгуулж, мэдээллийн төрөл бүрийн хэлбэрийг ашиглан олон нийтэд хүргэснээр нийгмийн даатгалын байгууллагын тухай олон нийтийн ойлголт, хандлага сайжирна.
Зорилт 3. Салбарын үйл ажиллагааг өөрийн цахим хуудсаар дамжуулан сурталчлах	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	НДЕГ-ын @sigomongolia сошиал хуудас нь 167000 дагагчтай бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагчийн тоо 38150 -аар нэмэгдсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын вэб, цахим хуудас болон @sigomongolia сошиал хуудас, инстаграмм хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, үйлчилгээг сурталчилсан рийл, постер мэдээлэл, контент, цаг үеийн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, подкаст, видео танилцуулга, заавар, шторк, чэлленж зэргийг ойлгомжтой байдлаар бэлтгэн түгээснээр олон нийтийг мэдээллээр хангаж, дагагчийн тоо нэмэгдэнэ.
Зорилт 4. Олон нийтийн цахим сүлжээ, сошиал медиа маркетинг	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Олон нийтэд нэр хүндтэй, олон дагагч бүхий сайтуудтай гэрээ байгуулан, өөрсдийн болон мэргэжлийн гэрээт байгууллагын бэлтгэсэн рийл,

ашиглах					постер мэдээлэл, контент, цаг үеийн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, подкаст, видео, танилцуулга, заавар, шторк зэргийг түгээлгэснээр нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх олон нийтийн ойлголт нэмэгдэнэ.
Зорилт 5. Эрсдлийн хариу арга хэмжээ, Мэдээлэлд мониторинг хийж, сөрөг мэдээллийг залруулах	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Жилийн турш	Цахим орчин, нийгмийн сүлжээнд нийтлэгдсэн ташаа мэдээ, сөрөг агуулга бүхий мэдээлэлүүдэд судалгаа хийж, залруулга, тайлбар өгч ажилласанаар олон нийтийн буруу ойлголтыг залруулж, нийгмийн даатгалын байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Урт хугацааны хөтөлбөрийн хүрэх үр дүнг жил, жилээр тодорхойлно. Тухайн жилд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл, постер, рийл, видео контент тоо, сошиал хуудасны дагагчдын тоо, хандалтын тоо болон хөндлөнгийн мониторингийн байгууллагын тайлан мэдээллээр хөтөлбөрийн үр дүнг тооцоно.

ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨГЖҮҮЛЭЛТ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ГАЗАР